



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хараат бус шинжээч томилох тухай/	4-6
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 06 дугаар сарын 26-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 12 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Ц.Мөнхтуяа,
М.Нарантуяа-Нара, Ж.Чинбүрэн, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Түвшин.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хараат бус шинжээч томилох тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хараат бус шинжээчид нэр дэвшигч Д.Далхжав оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголд оролцох хараат бус шинжээчид нэр дэвшигч Д.Далхжавын талаар танилцуулав.

Нэр дэвшигтэй холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан “Хараат бус шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Л.Энхнасан: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Доржийн Далхжавыг томилъё гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 09 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 09 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 09 цаг 12 минут

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Л.Энхнасан: Эрхэм гишүүд өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэж ирж Байнгын хорооны ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д хуралдааны ирцийг гишүүдийг сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа 10 дугаар тойрог Хүүгийн Болормаа, 8 дугаар тойрог Хүрэлбаатарын Булгантуяа, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг, Сархадын Зулпхар 6 дугаар тойрог, Цагаанхүүгийн Идэрбат, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа гэсэн гишүүд ирсэн байна.

Чөлөөтэй байгаа гишүүдийг танилцуулъя. 10 дугаар тойрог Цэндийн Баатархүү, 4 дүгээр тойрог Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Жудгийн Баярмаа, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нар чөлөө авсан байна. Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төсөл “Хараат бус шинжээч томилох тухай” хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй тул асуудлаа хэлэлцье.

Байнгын хорооны төслийн асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.8-д Байнгын хороо нь нэр дэвшигчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, ёс зүй туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчийг томилох ёстой байгаа.

Энэ хүрээнд хараат бус шинжээчид бүртгүүлсэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголд оролцох хараат бус шинжээчээр Доржийн Далхжавыг урьж ирүүлээд байна.

Нэр дэвшигчийн талаар мэдээлэл, хуулийн лавлагаа, Байнгын хорооны тогтоолын төслийг бол та бүхэнд тараасан байгаа.

Доржийн Далхжав Завхан аймгийн Нөмрөг сумын ерөнхий боловсролын 10 дугаар жилийн дунд сургуулийг 1977 онд төгссөн. ХХАА-н дээд сургуулийн Эдийн засгийн ангийг ХАА-н төлөөлөгч эдийн засагчаар 1983 онд төгссөн.

Төрийн захиргааны удирдлагын хөгжлийн институтэд Төрийн удирдлагын ангийг Төрийн удирдлагын менежерээр 1997 онд төгссөн, ХААИС-ийн магистрантыг 1999 онд төгссөн.

ХААИС сургуулийн докторантаар 2008 онд эдийн засгийн ухааны доктор төгсөж зэрэг авчээ.

Ажилласан байдлыг нь товч дурдвал НДЕГ-т 2000-2007 онд Орлого санхүүгийн хэлтсийн даргаар ажиллаж байсан байна. ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн санхүүгийн тэнхимд зөвлөх профессороор 2020 оноос одоо хүртэл ажиллаж байна.

Анх ажлынхаа гараагаа Завхан аймгийн Отгон сумын Оргил нэгдэлд эдийн засагчаар 1983 оноос ажиллаж байжээ.

Ингээд хараат бус шинжээч томилохтой холбогдуулан асуулт асуух үг хэлэх гишүүд нэрс өгнө үү. Асуулт асуух хүн алга.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй саналаар томилох тул та бүхэн санал хураалтдаа идэвхтэй оролцоорой. ингээд

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Хараат бус шинжээчийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.8 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлж гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэжил, ёс зүй, ур чадвар, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Д.Далхжавыг томилсугай.

Д.Далхжав нэр дэвшигчийн талаар гаргасан дүгнэлтээ сонсгол болгохоос ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө Байнгын хороонд хүргүүлэх нэр дэвшигчийн сонсголд оролцох дүгнэлт танилцуулахыг үүрэг болгосугай.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Энхнасан.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Доржийн Далхжавыг томилъё гэсэн санал хураалт хийе ээ.

75 хувиар дэмжигдлээ.

Өнөөдрийн хуралд оролцсон гишүүдэд баярлалаа. Доржийн Далхжавд баяр хүргэе. Баярлалаа хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

09.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА